



Үйл ажиллагааны тайлангийн
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
2017.07.20

КОМПАНИЙН ТУХАЙ

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн эрхэм зорилго нь “Монголын хөдөө аж ахуйн салбарын бараа, түүхий эдийн оновчтой тогтолцоо бүхий зах зээлийг хөгжүүлэх, оролцогчдод зах зээлийн бодит ҮНЭ хүргэх”-д оршино.

Улсын Их Хурлын 2011 онд баталсан “ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол улсын Засгийн газрын 2013 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 30 дугаар тогтоол, Төрийн өмчийн хорооны 2013 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 40 дүгээр тогтоолын дагуу “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийг үүсгэн байгуулсан.

Төрийн өмчийн хороо хуулиар олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд 2013 оны 02 дугаар сарын 28-ны өдөр 45 дугаар тогтоолоор “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн дүрмийг батлан ТУЗ-ийг 9 хүний бүрэлдэхүүнтэй

байхаар тогтоосон.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 73 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх 7 гишүүн шинээр томилогдсон. 2017 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга Э.Алтанзулыг чөлөөлж, хараат бус 3 гишүүнийг томилсон.

Удирдлага, зохион байгуулалт



Төлөөлөн удирдах зөвлөл

Нэр	Томилогдсон огноо	Томилогдох үеийн албан
Э.Сумъяа /дарга/	2016/10/07	Засгийн газрын хэрэг эрхлэн газрын ахлах референт
М.Энх-Амар	2016/10/07	ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга
Д.Оюун-Эрдэнэ	2016/10/07	ХХААХҮЯ-ны мэргэжилтэн
Б.Эрдэнэбулган	2016/10/07	ТӨБЗГ-ын Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
О.Мөнхсоёл	2016/10/07	ТӨБЗГ-ын мэргэжилтэн
С.Энхзориг	2016/10/07	ТӨБЗГ-ын Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн мэргэжилтэн
А.Батпүрэв	2017/05/25	Хараат бус гишүүн
В.Үнэнбат	2017/05/25	Хараат бус гишүүн, Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн гүйцэтгэх захирал
Ш.Энхтуул	2017/05/25	Хараат бус гишүүн, МУИС-ийн Бизнесийн сургуулийн багш
Г.Туяа	2017/01/20	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэр, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн тогтоолоор Гүйцэтгэх захирал Х.Баатарыг томилсон. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн

яамнаас өгсөн чиглэл зөвлөмжийн хүрээнд ноолуурын спот гэрээний туршилтын арилжааг 2013 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр эхлүүлсэн.

Удирдлага, зохион байгуулалт



Компанийн бүтэц



Компанийн үйл ажиллагааны хамрах хүрээ, тухайн жилийн төлөвлөгөөнөөс хамааран бүтэц орон тоог батлуулан, батлагдсан орон тооны хүрээнд хүний нөөцийн төлөвлөлтийг хийж ажилладаг бөгөөд 2017 эхний хагас жилийн байдлаар 40 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд Захиргаа, дотоод аудитын хэлтсийн захирлаар Т.Чинбат, стратеги судалгаа, хөгжлийн хэлтсийн

захирлаар Ж.Мягмарсүрэн, төлбөр тооцоо, ложистикийн хэлтсийн захирлаар Ц.Дуламсүрэн, мэдээллийн технологийн хэлтсийн захирлаар Д.Эрдэнэбат, арилжааны хэлтсийн захирлаар Т.Баасанжав нар тус тус томилогдон ажиллаж байна.

Санхүүгийн ҮЗҮҮЛЭЛТҮҮД



Компанийн товч үзүүлэлт /сая төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2017/01/01	2017/06/30
Орлогын тайлан		
Борлуулалтын орлого (цэвэр)	1,507.64	1,341.10
Татвар төлөхийн өмнөх ашиг	(184.85)	690.18
Татварын дараах ашиг (алдагдал)	(191.03)	621.16
Баланс		
Нийт хөрөнгийн дүн	1,795.86	2,756.66
Үүнээс: Үндсэн хөрөнгө	290.06	249.34
Арилжаанд оролцогч		
Гишүүдийн тоо	11	11

Биржийн хувьд байгуулагдсан цагаасаа хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн зах зээлийн зохицуулалттай арилжааг зохион байгуулж ирсэн бөгөөд тайлант хугацаанд түүхий эд, таваарын арилжааны зах зээлийн хөрвөх чадварыг дээшлүүлж, ложистикийн нэгдсэн төв бий болгох, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, зах зээлд оролцогчдын хүрээг тэлэх стратегийн зорилго дэвшүүлж, үүнтэй уялдуулан 2017-2020 оны бизнес төлөвлөгөөгөө боловруулан ТУЗ-аар батлуулсан. Түүнчлэн технологийн шинэчлэл хийх,

түүгээр дамжуулан бэлэн бараа, түүхий эдэд суурилсан үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааг нэвтрүүлж, зах зээлд оролцогчид болон биржийн орлогыг жилийн турш тасралтгүй бүрдүүлэх нөхцөлийг хангах ажлыг шат дараатай явуулж ирлээ.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Монгол Улсын Их хурлын 2015 оны 70, Засгийн газрын 330, Төрийн өмчийн хорооны 699 дүгээр тогтоолуудаар “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн төрийн эзэмшлийн хувь 34 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гаргахыг зөвшөөрч, энэ ажлыг 2015-2016 онд зохион байгуулахаар шийдвэрлэсэн байдаг. Бирж энэхүү тогтоолын хэрэгжилтийн бэлтгэл ажлыг хангаж, нэмэлт хөрөнгө оруулалт татах замаар технологийн болон логистик дэд бүтцийн шинэчлэл хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Нэмэлт хувьцаа худалдан авахаар хөрөнгө оруулалтын гэрээ хийсэн нэр бүхий 5 ААН-ийн зүгээс гэрээгээр тохиролцсон хугацаанд төлбөр хийгээгүй тул гэрээг хүчингүй болгоод байна.

Иймд цаашид төрийн өмчийн эзэмшил хувийг 51 хувьд байлгаж, нээлттэй хувьцаа гаргахаар холбогдох саналаа эрх бүхий байгууллагуудад хүргүүлээд байна.

АРИЛЖААНЫ ТОЙМ

Хөдөө аж ахуйн бирж 2017 оны эхний хагас жилд нийт 88 удаагийн арилжаагаар 424.2 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий спот гэрээний арилжаа хийсэн байна. Үүнд: 5097 тонн ноолуур, 1359,9 тонн хонины ноос, 79,8 тонн тэмээний ноос, 1203 тонн ямааны завод ноос, 1131 тонн хонины спот гэрээг тус тус арилжсан

байна.

Тайлант хугацаанд Сүхбаатар, Хэнтий, Хөвсгөл, Говь-Алтай, Баянхонгор аймгуудад ноолуурын өргөтгөсөн дуудлага худалдаа зохион байгуулж ажиллалаа.



“Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль” болон “Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам”-д заасны дагуу арилжаанд оролцох үндсэн шалгуур нь зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас авсан байхаар заасан бөгөөд энэхүү зохицуулалтын дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос 11 хуулийн этгээд тусгай зөвшөөрөл авсан байна. Мөн Биржийн тухай хуульд заасны дагуу “Хоршоо” байнгын бус гишүүнээр арилжаанд оролцож болох ба тусгай зөвшөөрөл авах шаардлагагүй

байдаг.

2016 онд 1 хоршоо биржийн байнгын бус гишүүний гэрээ байгуулж, арилжаанд оролцож байсан бол энэ оны эхний хагас жилд байнгын бус гишүүн байгууллага арилжаанд оролцсонгүй.

Хоршоод биржийн арилжаанд анхан шатны тордолт хийсэн бараа, түүхий эд нийлүүлэх байдлаар оролцох ёстой бөгөөд хөдөө орон нутагт биржийн арилжааны талаарх мэдээлэл хомс байдгаас гадна Хоршооны тухай хууль, НӨАТ-ын тухай хуулийн зарим зохицуулалтаас шалтгаалан биржийн байнгын бус гишүүд нэмэгдэхгүй байна.

Биржийн гишүүдийн тоо

	2013	2014	2015	2016	2017
Шинээр гэрээ байгуулсан	32	-			
Гэрээгээ сунгасан	-	23	17	11	14
Байнгын бус гишүүний тоо	-	-	1	1	1
Нийт гишүүний тоо	32	23	18	12	15



Өнгөрсөн 2013, 2014, 2015 онуудад Хаан Тэлмэн болон Ханбүргэд хэнтий брокерын компаниуд хамгийн өндөр дүнтэй арилжааг хийж байсан бол тайлант хугацаанд ч дээрх 2 компани хамгийн өндөр дүнтэй арилжааг хийжээ.

Байнгын гишүүдийн арилжааны дүн ба хэмжээ
2017/06/30-ны байдлаар

№	Брокерын компанийн нэр	Арилжааны дүн, төгрөгөөр
1	Ханбүргэд хэнтий	133,734,863,000
2	Хаан тэлмэн	112,780,379,600
3	МЭТУ	69,894,008,600
4	Бадар хундага Оргил	46,481,647,000
5	Танан дээж трейд	30,162,913,000
6	Рояал кашимер	15,890,190,000
7	Цэц-Инвест	8,282,814,000
8	Алтан шагай импэкс	6,996,824,000
НИЙТ ДҮН		424,223,639,200

ИТГЭМЖЛЭГДСЭН ЭТГЭЭД



Үйлдвэр, Хөдөө аж ахуйн сайдын 2013 онд баталсан биржээр арилжаалах бараа, түүхий эдийн жагсаалтын дагуу барааны тодорхойлолтыг 7 төрлөөр боловсруулсан бөгөөд биржийн арилжаанд завод ноосны тодорхойлолтыг бие даасан барааны төрөл болгосноор барааны тодорхойлолт 8 төрөл болж нэмэгдсэн.

Бирж байгуулагдсан цагаас эхлэн агуулахуудад биржийн итгэмжлэл олгож эхэлсэн. Итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг биржийн ерөнхий журамд заасны дагуу гүйцэтгэх захирал батлан мөрдүүлж байна. 2014 оноос эхлэн бирж итгэмжлэл хүсэгчтэй 1 жилийн хугацаатай итгэмжлэлийн гэрээ байгуулж ажилласан.

Итгэмжлэгдсэн этгээдийн тоо

	2013	2014	2015	2016	2017
Итгэмжлэгдсэн агуулах /Улаанбаатар/	20	20	16	14	9
Итгэмжлэгдсэн агуулах /орон нутаг/	18	4	11	4	
Итгэмжлэгдсэн тээвэрлэгч	2	-	-	-	1
Нийт итгэмжлэгдсэн этгээд	40	24	27	18	10



Бирж нь бараа түүхий эдийн зах зээлийн өнөөгийн нөхцөл боломж, онцлогоос шалтгаалан худалдагч, худалдан авагч талуудын бараа, түүхий эд худалдах, худалдан авах гэрээг үндэслэн төлбөр тооцоо хийж гүйцэтгэх буюу хоёр талт клирингийн зарчмаар төлбөр тооцоо, клирингийн үйлчилгээг үзүүлж ирсэн. 2016 оны 4 сараас эхлэн Клирингийн гишүүд өөрийн харилцагчдынхаа гэрээний төлбөр тооцоог гүйцэтгэх боломжтой болсон. Биржээр 2017 оны эхний хагас жилийн байдлаар нийт 582 хэлцлийн 423 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийгдсэний 78.9 тэрбум

төгрөгийн гэрээний төлбөр тооцоо Биржээр, 344.8 тэрбум төгрөгийн төлбөр тооцоо клирингийн эрхтэй брокерийн компаниудаар дамжин хийгдсэн байна.

Бид Клирингийн бус гишүүдээс баталгаат болон анхдагч дэнчин, Клирингийн гишүүдээс баталгаат дэнчин, барьцаа хөрөнгө шаарддаг бөгөөд арилжаанд оролцогчид гэрээний үүргээ бүрэн биелүүлсэн, биржид ямар нэгэн ер төлбөргүй тохиолдолд тухайн дэнчин болон барьцаа хөрөнгийг буцаан шилжүүлдэг.



1. 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө
2. 2017-2020 онд хэрэгжүүлэх бизнес төлөвлөгөө
3. 2017-2022 онд хэрэгжүүлэх стратегийн төлөвлөгөө /төслөөр/
4. Худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөө
5. Үйл ажиллагааны дотоод журам
6. Хөдөлмөрийн харилцааны дотоод журам
7. Эрсдэлийн бодлогын баримт бичиг
8. Эрсдэлийн сангийн журам
9. Арилжааны журам
10. Төлбөр тооцооны журам
11. Хяналтын журам
12. Гишүүнчлэлийн журам
13. Агуулахын итгэмжлэлийн журам
14. Тээврийн итгэмжлэлийн журам
15. Боловсруулаагүй ноолуурын дуудлага худалдааны түр журам
16. Биржийн ажилтны ёс зүйн дүрэм
17. Нууц хамгаалах, нууц баримт бичиг ашиглах журам
18. Албан томилолтын журам
19. Дотоод аудитын дүрэм
20. Мэдээллийн технологийн аюулгүй байдлын журам
21. Хүний нөөцийн бодлогын баримт бичиг, хүний нөөцийн хөтөлбөр /төслөөр/
22. Ажилтны ажлын үнэлгээ тооцох аргачлал, урамшуулал олгох журам /төслөөр/
23. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг /төслөөр/